



Захиргааны хэм хэмжээний  
 актын улсын нэгдсэн бүртгэлд  
 2022 оны 06 сарын 29-ны  
 өдрийн 5879 дугаарт бүртгэв.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
 БАЯНЛИГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
 ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2022 оны 06 сарын 09 өдөр

Дугаар 8/11

Хатан суудал

**Хог хаягдлын хураамжийг  
 шинэчлэн тогтоох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1. Сумын нутаг дэвсгэрт оршин сууж буй айл өрх, аж ахуйн нэгж, үйлдвэр үйлчилгээний газрууд, албан байгууллагуудаас гарч байгаа ахуйн болон хуурай хог хаягдлын төлбөр хураамжийн хэмжээг хавсралтад зааснаар шинэчлэн баталсугай.

2. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх жолоочтой гэрээ байгуулан, график гарган цаг хугацаанд нь ачуулах, тэдний нийгмийн болон хөдөлмөр хамгаалал, цалин урамшууллыг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга (О.Мөнхбат)-д даалгасугай.

3. Батлагдсан тарифыг сурталчлан хэрэгжүүлж, төлбөр хураамжийг бүрэн төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга (О.Мөнхбат), Татварын улсын байцаагч (Ш.Жаргалмаа) нарт үүрэг болгосугай.


4. Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тогтоолыг холбогдох бичиг баримтын хамт хүргүүлэх болон тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Б.Эрдмаа)-д даалгасугай.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит 7 дугаар хуралдааныг 7/08 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  С.АМАРСАНАА



648801060



Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн  
ээлжит 8 дугаар хуралдааны 8/11 дүгээр  
тогтоолын Хавсралт

**ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**


№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	Сард төлөх хураамж /төг/	
1	Айл өрх	Төв суурин	Өвлийн улирал	Төгрөг	3.000
			Зуны улирал	Төгрөг	3.000
			Сард 2 удаа ачуулах тохиолдод дуудлагаар ачна. Дуудлагаар ачуулах тариф	Төгрөг	5,000
2	Төрийн байгууллага	ИТХурал	Төгрөг/ сар /	15.000	
		Засаг даргын Тамгын газар	Төгрөг/ сар /	15.000	
		Сургууль	Төгрөг/ сар /	20.000	
		Цэцэрлэг	Төгрөг/ сар /	15.000	
		Цэргийн анги	Төгрөг/ сар /	20.000	
		Эмнэлэг	Төгрөг/ сар /	15.000	
		Эмийн сан	Төгрөг/ сар /	15.000	
		Холбоо	Төгрөг/ сар /	10.000	
		Банк	Төгрөг/ сар /	15.000	
		Соёл	Төгрөг/ сар /	15.000	
	Шатахуун түгээх станц	Төгрөг/ сар /	15.000		
3	Үйлчилгээний зориулалттай, Аж ахуй нэгж, байгууллага /Үсчин, Цайны газар, авто засвар/		Төгрөг/ сар/	15.000	
	Хүнсний дэлгүүр	30 м2 дээш	Төгрөг/ сар/	15.000	
30 м2 доош		Төгрөг /сар	10.000		
4	Аялал жуулчлал амралт сувиллалын газар		Төгрөг / 5-8 сар /	10.000	
5	Уурын зуух /10 сарын 1нээс 4 сарын 30 /, нам даралт ашигладаг аж ахуй нэгж, айл өрх 1 машин ачилтын хөлс		Төгрөг /сар/	10,000	
6	Ил задгай худалдаа эрхлэгчид		Төгрөг	20.000	

**ГАЗРЫН ХЭВЛИЙ, АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН АЖ АХУЙ НЭГЖИЙН ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ**

№	Хог хаягдлын төрөл	Нэгж	Нэгжээс авах төлбөр /төг/
1	Аюултай хог хаягдал	Төгрөг /кг/	1200
2	Энгийн хог хаягдал	Төгрөг /кг/	600

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖ**

№	Хог хаягдлын төрөл	Нэгж	Нэгжээс авах төлбөр /төг/
1	Аюултай хог хаягдал	Төгрөг / кг /	1200
2	Энгийн хог хаягдал	Төгрөг /кг/	300



Бүртгэлийн № 6.0.  
Баянхонгор аймгийн Баянчил сумын нотариатын  
үүрэг /үндэслэл... н. Уугуулмаа... би энэ  
хуулбарыг үнэн гэдгээг заруулав.  
Үйлчилгээний хэмжээ 15.0 төгрөг хураав.  
Нотариатын үүрэг гүйцэтгэгч н. Уугуулмаа  
2022 оны 06 сарын 17